

ДОРЖ ШҮГДЭН



Манай эрин үеийн сахиус

ХАМАГ АМЬТНЫГ ТӨГС ГЭГЭЭРЛИЙН МӨРД
ХӨТЛӨГЧ, ДЭЭДИЙН НОМЫН РАШААН,
АДИС ХҮЧЭЭ ХАРАМГҮЙ БУУЛГАГЧ, СҮСЭГ
БИШРЭЛИЙН ХИРГҮЙ АРИУН БАРИЛДЛАГАТ
ДАМЖЛАГЫН БАГШ НАРТАА ЭНЭХҮҮ ЗУРАГТ
ТОВХИМАЛЫГ ЗОРИУЛАВ.

Мөн түүнчлэн Жалчин Доржшүгдэн
САХИУСАНД СҮСЭГЛЭН ШҮТДЭГ УЛАМ БҮР
ТОО НЬ ӨСӨН НЭМЭГДЭЖ БАЙГАА СҮСЭГТЭН
ОЛОНД ЗОРИУЛАН ИХ САХИУСЫН МӨН ЧАНАР,
ЗОРИЛГО, ТААЛАЛ, ЗАРЛИГ, ЛАГШИНГИЙН
ЭРДЭМ ЧАДЛЫН ТАЛААР ҮЗҮҮЛЭЭД ЗОГСОХГҮЙ
ХЭРХЭН ТООЛШГҮЙ ОЛОН ХУТАГТАН МЭРГЭД
ДЭЭДЭС БАГШ НАР, ТҮҮНИЙ ДОТОР БУРХАН
БАГШИЙН ҮЕИЙН ДЭЭДЭС МЭРГЭД ЭНЭХҮҮ
САХИУСЫГ ШҮТСЭЭР ИРСЭН ТУХАЙ ЭНД
ӨГҮҮЛЭХ БОЛНО.

ГАРЧИГ

Анхдугаар хэсэг:	Төөрсөн нь
Хоёрдугар хэсэг:	Номын сахиус нар
Гуравдугаар хэсэг:	Доржшүгдэн, түүний зорилго
Дөрөвдүгээр хэсэг:	Уг анхны багш нар: Бирвапа болон Сажа Бандита
Тавдугаар хэсэг:	Дүлэин Дагба Жалцан
Зургаадугаар хэсэг:	Банчин Эрдэнэ Сонам Дагва
Долоодугаар хэсэг:	Бүрүлгү Дагба Жалцан хувилгаан
Наймдугаар хэсэг:	Бүрүлгү Дагба Жалцан таалал болсон нь
Есдүгээр хэсэг:	Бурхан уу, эсвэл Тэнэмэл сүнс үү
Аравдугаар хэсэг:	Сажавын сүмд зорчсон нь
Арван нэгдүгээр хэсэг:	Дагбу Бадамважра Түшидийн ариун орноо зорчсон нь
Арван хоёрдугаар хэсэг:	Дээрхийн Гэгээнтэн Авралт Богд Пабонка Очирдарь
Арван гуравдугаар хэсэг:	Дээрхийн Гэгээнтэн Авралт Богд Тижан Очирдарь
Арван дөрөвдүгээр хэсэг:	Олдсон нь





Их Шигтэн
Бувана



Жигжиг бурхан



Манзушир бурхан



Чойжоо



Шалзи



Дүлзин Дагба Жалцан

- Эрин цаг бүхэнд -
Гагцхүү энэрэн нигүүсэхүй хийгээд, билиг билгүүнийхээ үүднээс төгс гэгээрсэн бурхад аливаа эрин цагийн янз бүрийн хүмүүсийн сэтгэл оюунд таарсан дүр байдлаар хувиран, тэдэнд туслан авардаг байжээ.



Дорж Шүгдэн



Шувуу



Бурхан багш



Зүүр



Богд Зонхов




Банчинин Эрдэнэ Соном Дагба





Банчинин Эрдэнэ Соном Дагба



АНХДУГААР ХЭСЭГ:
ТӨӨРСӨН НЬ



Myz Myz
Myz...





Ий уй уй



Хүү минь!
Юу болоов?
Яагаад уйлаав?



Би төөрчихлөө. Ээж
минь олддоггүй,
Би айгаад байна



Битгий уйл! Ээж нь
энэ хавьд ойрхон л
байгаа байх. Чи энд
айх хэрэггүй дээ!

Ээ...

Та яаж
мэдэж байгаа юм бэ?
Ээж маань намайг
олохгүй, би энд ганцаараа
үлдчихвэл яах юм бэ?
Би гэртээ тэгээд яаж
харих юм бэ?



Чи энд сайн хамгаалагдаж байгаа тул айх юм байхгүй. Бүх юм сайн сайхан болохыг чи өөрөө харах болно.

Хамгаалагдсан гэдэг чинь юу гэсэн үг вэ?



Чи дээшээ хар даа. Тэр гуулин бурханы дүрийг харж байна уу? Хэн болохыг нь чи мэдэх үү?



Хөөх,

Хөөх, Энэ чинь хэн юм бэ?



Үүнийг хамгийн
дээд сахиусан бурхан
ДОРЖ ШҮГДЭН
гэдэг юм.

Сахиус Дорж Шүгдэн
гэнээ...? Хэнийг сахин
хамгаалдаг юм бэ?



Ммм.
Маш олон зүйлсийг
сахин хамгаалдаг юм.
Гэхдээ яг одоо бол
чамайг сахин
хамгаалж байна.

НАМАЙГ УУ?

Тийм ээ,
Дорж Шүгдэн сахиус
үнэхээр олон зүйлсийг
сахин хамгаалж байдаг
бөгөөд биднийг ч сахин
хамгаалж байгаа нь тодорхой.
Тиймээс, чи юунаас ч
айсны хэрэггүйдээ
хүү минь.

Намайг Николас
гэдэг.





За ,Николас минь,
Дорж Шүгдэн чиний
ээжийг дагуулаад ирэн
иртэл эндээ хүлээгээд
байж бай.

Тэр үнэхээр дагуулаад
ирж чадах болов уу?



Дорж Шүгдэн
сахиус чиний төлөө юу
ч хийж чадах тул санаа
бүү зов. Ээжийгээ иртэл
сахиусын талаар сонсмоор
байна уу.



Тэгье




Дорж Шүгдэн бол
энгийн нэгэн сахиус биш
харин Номын их хүчит
сахиус юм аа.


Номын сахиус
гэдэг чинь юу
гэсэн үг вэ?



Үүнийг
тайлбарлахын
өмнө.. Бурхан багш
гэж хэн болохыг чи
мэдэх үү?




Мэдээж,
Бурхан багш гэж хэн
болохыг мэдэлгүй яах вэ.
Хүн бүр мэддэг шүү дээ.
Маш их ухаантай болтлоо
модон доор суугаад байдаг
алдартай хүн шүү дээ.



Николас минь, Тэр
зүгээр л модон доор
суугаад байгаагүй юм
шүү дээ.

Тэрээр
амьдрал, амьдралын зовлонгийн
шалтгааныг бясалган сууж байсан
юм. Эцэст нь тэрээр бүх асуултын хариуг олж
төгс гэгээрсэн билээ. Тэрээр олон амьтанд
сургааль номоо хайрласан бөгөөд тэр үеэс
эхлэн олон сүм хийдүүд ч баригджээ. Бурханы
сургааль маш үнэ цэнэтэй тул одоо хүртэл
хадгалагдсаар иржээ. Тиймээс Бурхан багш
бол зүгээр нэг ухаантай хүн төдий
байгаагүй юм шүү.
Хүү минь.




За.
Би одоо л ойлголоо.
Та сахиусын түүхээ
яриад өгөөч!




ДЭД ХЭСЭГ:
НОМЫН САХИУС НАР






Бурхан багш маань сургахдаа,
зовлонг арилгах цор ганц арга
бол бусдыг асран нигүүсэх
сэтгэлийг өөртөө үүсгэх, улмаар
юмсын БИ-үгүйн мөн чанарыг
ойлгоход оршино гэжээ.



Энэ сургаалийг Дарма буюу Ном,
гэх бөгөөд Бурхан багшийн
айлдсан зөв амьдрах арга хэмээн
алдаршсан юм. Бурханы энэхүү
ном сургаалийг



мартагдаж гээгдэхээс сахин
хамгаалахын тулд тусгай сахиус нар
буй болсон түүхтэй юмаа. Эдгээр
сахиусууд нь бидний ном сургаалаа
ухааран мэдэх явцад гардаг саад
бэрхшээлийг арилгаад зогсохгүй
бидний өдөр тутамын ямар ч саад
бэрхшээлийг арилгаад өгдөг гайхам
ачтай сахиус нар юм аа.



Сахиус нар нь дотроо төгс гэгээрсэн болон эс гэгээрсэн сахиус нар гэсэн хоёр янз байдаг



Гэгээрсэн сахиус нь Бурханы хувилсан дүр юм. Сэтгэв сахиус бол Цаглашгүй гэрэлт бурханы догшин дүр юм.



Хэдийгээр тэд гаднаасаа өөр өөр харагдах боловч, бүгд л адилхан байдаг. Яагаад гэдгийг нь мэдэж байна уу?

Яагаад гэвэл тэд бүхэн бурхад юм



Яг зөв. Маш сайн байна



Жишээ нь: энд Манзушир бурханы хувилгаан Дөрвөн нүүрт Гомбо Шалши гэдэг сахиус байна.



Эс гэгээрсэн сахиусууд ч гэж байдаг бөгөөд тэдгээрийг анх хийн биетэй догшид байхад нь дээдэс лам нар номхоруулан, номыг сахиулахын тулд ам тангараг авхуулсан тул сахиус болцгоосон ажээ.



Дорж Дагдан, Найчун сахиус сүүлийн 300 жилийн турш Төвдийн төрийн Чойжин лам нарт оршиж, Далай лам нарт зөвлөгөө өгч ирсэн түүхтэй юмаа.



Бид гэгээрсэн сахиус нарт л аврал одуулахаас бус эс гэгээрсэн сахиусан нарт аврал одуулж болохгүй.

Яагаад?



Яагаад гэвэл эс гэгээрсэн сахиус нар биднийг төгс гэгээрэлд хүргэн өгч чадахгүй тул бид зөвхөн Бурхан, Ном, Хуварга гуравт л аврал одуулах учиртай юм.



Өөр өөр цаг үед өөр өөр сахиус хувилж байдаг. Тухайн цаг үеийнхээ амьтан хүмүүсийн үйлийн үрээс хамааран, тэдгээрийн элдэв янзын зорилго хүслийг биелүүлэхийн тулд янз бүрийн сахиус нар элдэв дүрээр хувилдаг ажээ.

Tibet

Төвдэд шашин номыг дэлгэрүүлэхийн тулд номын дээдэс мэргэд Энэтхэгийн маш олон Номын сахиусыг залж ирүүлжээ.

India

Яагаад Шашин номыг газар бүр дэлгэрүүлэх нь тийм их чухал болохыг чи мэдэж байна уу?

Мэдэж байна.
Ном шашны хүчээр л бид амьдралд тохиолдох зовлонгоо арилгаж Төгс Гэгээрэлийг олж болно шүү дээ.




Оюун санааны түвшинд биднийг шашин номоо үзэж, номоо ухаарахад гарах аливаа саад бэрхшээлийг арилган, сэтгэлийг амирлуулан төвшитгөж, билэг ухааныг маань арвитгагахад Номын сахиус нар л тусалж хөтөлдөг билээ.




Бидний өдөр тутамын амьдралын явцад тэд нар бидний бэрхшээл саадыг арилган, номоо саадгүй үзэх гадаад нөхцлийг бүрдүүлэн эд зүйлсээр хангадаг юмаа.

Жишээ нь:
Хэрэв бид хангалттай мөнгөтэйн дээр гэр бүл маань эв найртай, түвшин амгалан байх юм бол бидэнд ном үзэхэд маань илүү амар байхын дээр номын хүчээр бид зовлонгоосоо салж болно. Ингэснээр бид төгс гэгээрч, Бурханы хутгийг олж болно гэсэн үг л дээ.




Тийм үү?

Тийм үү?
Энэ үнэхээр догь юм аа.



Мөн түүнчилэн Номын
сахиусууд өвчин, осол
эндэгдэл зэрэг гай
барцадаас хамгаалан
сахьдаг ажээ.



Ер нь гэгээрсэн номын
сахиусууд биднийг
байнга хамгаалж байх
болно.

Гуравдугаар хэсэг
ДОРЖ ШҮГДЭН ТҮҮНИЙ ЗОРИЛГО





Дорж Шүгдэн бол 350
жилийн өмнө боссон
гэгээрсэн сахиус бөгөөд
билиг оюуны бурхан
Манзушир Бурханы
хувилгаан юм.



Тэгэхээр энэ
хоёр адилхан гэсэн үг
үү? Дорж Шүгдэн сахиус
болон Манзушир бурхан
нэг болох нь ээ?



Хоёрдугаар Бурхан багш хэмээн
алдарсан Богд Зонховын дээдийн
шашин сургаалийг сахин хамгаалахаар
Дорж Шүгдэн бурхан нь номын
сахиус болон хувирч, өнөөдөр хүртэл
шүтэгдэн иржээ.



Тийм ээ!!
Нэг гэсэн үг.



Богд Зонхов (1357-1419) бол Төвдэд амьдарч байсан лам бөгөөд Төвдийг доройтох үед Бурханы шашин сургаалыг дахин сэргээн уг анхны хэлбэрт нь оруулан, дэлгэрүүлсэн гавьяатай номч гэгээнтэн байжээ.



Тэрээр Төвдэд дэлгэрч байсан Буддын шашны бүх урсгалуудын хамгийн сайн сайхныг сорчилон аваад Шар малгайтны ёс гэж алдаршсан Гэлүгийн шашныг дэлгэрүүлжээ.




Богд Зонхов бол Энэрэн нигүүсэхийн бодьсатва Аряабал, билиг ухааны бодьсатва Манзушир болон хүч чадлын Бодьсатва Очирвааний хувилгаан хэмээн алдаршсан юм.



Дорж Шүгдэн бол алдартай мэргэд багш нарын урт үүх түүхтэй сахиус агаад урдын дүрүүд нь Бурхан багшийн үед ч байсан юм шүү дээ.



Манзушир бурхан нь
Бурхан багшийн шавь
болон хувирч байжээ.




“Манзушир бурханы
орныг үзүүлэгч” сударт
амьтны тусын тулд
Манзушир бурхан
тоолшгүй олон дүрээр
хувирдаг гэжээ..

Аливаа орон газрын хүн амьтны тухайн цаг
үеийн тусгай хэрэг тусыг бүтээхийн тулд
Бурхад байнга янз бүрийн дүр байдлаар хувирч
байдаг юм.



Гайхмаар
юм... Бурхад
үнэхээр ач тустай
юм аа. Тийм биш
гэж үү? Бурхан
бүхэн дандаа ийм
байдаг уу?

Тийм ээ,
Дандаа.



ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ
ЭРТНИЙ БАГШ НАР:
БИРВАПА болон САЖА БАНДИТА





Дорж Шүгдэн сахиусын хамгийн эртний тэмдэглэгдэж үлдсэн дүр бол Энэтхэгийн алдарт Наян дөрвөн Шидтэн нарын нэг Махасидда Бирвапа(837-909) байлаа.

Махасидда Бирвапа бол Манзуширийн хувилгаан байсан бөгөөд өөрийн гүн гүнзгий сургааль номлолоороо алдартай байсны дээр ид шид олныг үзүүлдэг байснаараа ч гайхамшигтай нэгэн байжээ. Тэрээр нэгэн удаа ид шидийнхээ хүчээр нарыг ч тэнгэрт зогсоож байсан гэдэг.

Бирвапаг хар даа. Тэр яаж сүм хийдэд эмэгтэй хүн авчирч байна аа.

Энэ бол гутамцигтай явдал. Бид нар түүнийг сүмээс хөөх хэрэгтэй.

Тэрээр өдрийн цагаар судрын сургаалийг судлан, шөнийн цагаар нууц тарнийн ном үзэж байв.

Бирвапа гэдэг нь Муу хүн гэсэн утгатай үг юм. Наланда хийдийн зарим хуваргууд түүнийг эгэл жирийн эмэгтэй нартай зуугацаж байна гэж андуурч байсан тул ингэж нэрлэжээ.



Хөөх, Нархажод! Их
Амгалангийн Дагина болон
түүний нөхдүүд нар аа!

Та бүхэн намайг машид
адиславай.

Үнэн хэрэгтээ тэдгээр эмэгтэйчүүд
нь Нархажод түүний хот мандалын
нөхөд байсан юм.


Бирвапа сүүлд нь Төвдэд Сажийн ёсны их лам
Сажа Бандита (1182-1251) хэмээн алдаршсан
Сачин Гунгаа Жалчин болж төрсөн байна.



29



Сажа Бандита бага
залуугаасаа л оюун
ухаан, цэцэн тунгалаг
хэмээн алдаршсан
нэгэн байв.




Сажа Бандитагийн нэр алдар газар сайгүй түгсэн байсан тул Монголын их хаан хүртэл түүнд машид сүсэглэн улмаар Буддын шашинд орж байв.




Сажа Бандита дараагийн төрөлдөө Бутон Ринчин Дув (1291-1364) болон төржээ.




Тэрээр балчир хүүхэд байхаасаа л Манзүшир бурхантай нүүр тулан учирдаг байв.



Бутон Ринчин Дув
нигүүсэл болон бодь
сэтгэлээрээ алдаршин,
ном тавих болон бусад их
үйлийг бүтээжээ.



Тэрээр ном номлох, туурвихыг
голлон бүтээж, эртний Энэтхэг
хэлнээс олон судар ном
орчуулжээ.



Түүний орчуулан, хэвлэсэн олон
ном зохиолын дотор Ганжуур болон
Данжуурын тайлбар 26 боть ном ордог.
Ганжуур гэдэг нь Бурхан багшийн
өөрийн зарлигийн орчуулга бол Данжуур
гэдэг Шашдирын орчуулга гэсэн үг
ажээ.

ТАВДУГААР ХЭСЭГ
ДҮЛЗИН ДАГБА ЖАЛЧИН





Бутон Ринчин Дув дараа нь Төвдийн төв хэсэгт Дүлзин Дагба Жалцан хэмээх нэрт лам болон төрөв. Тэрээр Зонховын Богдын найман шадар шавь нарын нэгэн байсан бөгөөд түүний нэр Дүлзин гэдэг нь хувраг хүний сахил болох Винайн ёсыг баригч гэсэн утгатай ажээ.




Дүлзин лам өөрийн ариун ёсыг сайтар барьдагаараа алдартай байгаад зогсохгүй шашин дэлгэрүүлэх ариун үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсны нэг бол анх алдарт Гандан хийдийг бүтээх үйлсийг гардан хийсэн явдал юм.

Дүлзин минь, та энэхүү хийдийг бариулснаараа асар их буяныг хураалаа даа.

Энэ хийд бол Богд Зонхов багшдаа өргөсөн миний өргөл юм аа.



1409 онд баригдаж дууссан энэ хийд нь Богд Зонховын үндэслэсэн Гэлүгийн ёсны хамгийн анхны бөгөөд хамгийн нөлөө бүхий сүм нь болсон юм.




Нэгэн өдөр Богд Зонхов ном
айлдаж байв.




Нэгэн цагаан тагтаа Богд Зонховыг
ном айлдан байх үеэр түүний арслант
ширээг тойрон нисээд байв.



Богд Зонховыг тойрон нисэх
гэрхүү тагтааг номын сахиус
Найчун гэдгийг Дулзин лам
таньжээ.



Ном өндөрлөсний дараа лам хувргууд бүгд тарж, сүмд Дүлзін ламаас өөр хүн үлдсэнгүй.



Найчүн минь!
Та юунд
багш ламын
минь номыг
үймүүлнэ вэ?



Та юу хүсээд
байна вэ?



Тагтаа хувиран өөрчлөгдөж...




Надад
чиний тусламж
хэрэгтэй
байна.

Нэгэн хүү болов.





Энэ төгс дээд сургааль номыг сахин хамгаалах нийтийн бус сахиус хэрэгтэй байна.



Бурханы шашныг ерөнхийд нь сахина гэж Гүрү Ринбүүчид би ам өгчихсөн тул би өөрөө үүнийг хийж чадахгүй байгаа юм.



Би юу?

Дулзин минь, та Богд Зонховыг тодруулан, сургасан Нагаржунай Төв үзэл сургаалийг хамгаалагч, Гандангийн нийт бусын сахиусаар босогтун.



Та сахиусаар босохоо амлагтун




Тэгье. Зонхов багшийнхаа төлөө мэдээж болно. Би сахиусаар босъё. Би тангараглаж байна!



Ам тангарагаа
бүү мартагтун!




Богд Зонховын
шашны тэргүүн болж,
Гандангийн ширээнд
залрагтун.




Дүлзин лам маш их нэр хүндтэй байсан тул
Богд Зонховыг таалал болсны дараа түүнийг
Богд Зонховыг орлох Гандан Типад хүртэл
залахаар урьж байжээ.



Ийм
өндөр хүндэтгэл үзүүлсэнд
баярлан талархаж байна.
Гэвч би татгалзаж
байна.




Жалцав Жи! Та л
Гандангийн ширээнд
залрах хэрэгтэй. Харин би
өөрийгөө Богд Зонховын
шашныг дэлгэрүүлэх үйл
хэрэгт зориулахыг хүсч
байна.



Дүлзин лам дараа нь Богд Зонховын шашин
номын болон Гандан хийдийн төлөө
маш ихийг хийж бүтээсэн бөгөөд өөрийн
амьдралын сүүлийн өдрүүдийг гүн гүнзгий
бясалгал хийж өнгөрөөсөн юм.


ЗУРГААДУГААР ХЭСЭГ
БАНЧИН СОНАМ ДАГБА



Дараа төрөлдөө Богд Дүлзин бээр 1478 онд үнэхээр эгэл бусын мэргэн Банчин Эрдэнэ Соном Дагба болон төржээ.



Тэрээр маш нэр хүндтэй мэргэн лам байсан бөгөөд Гуравдугаар Далай ламын багш нь байсан юм.



Банчин Эрдэнэ Соном Дагба бол хосгүй лам байв. Тэрээр нэгэн төрөлдөө Гэлүг ёсны гурван гол сүм болох Гандан, Сэра болон Брайвүн хийдүүдийн хамба лам байсан цор ганц лам юм.




Мөн тэрээр Жүд тарнийн дацангийн хамба лам болж,



XV Богд Зонховын ширээг залгамжлагч Гандан Тивра болсон юм.




Банчин Эрдэнэ Соном Дагва маш номтой, их хурц ухаантай лам байжээ. Тэрээр гүн ухааны 11 боть ном бичсэн нь машид алдаршжээ.



Эдгээр номуудыг Гандан Шарээ болон Брайвун Лосэлин зэрэг алдарт дацангуудад гэвшийн дамжааны гол сурах бичиг болгон өнөөдөр хүртэл сурч судалж байна. Гэвч гэдэг нь эрдэмийн цол.

Тэдгээр 11 боть номуудыг бусад том дацан сургуулиудад ч гэсэн харьцуулах журмаар судалдаг билээ.



Банчин Эрдэнэ 1554 онд таалал болохынхоо өмнө Дээд хэсэг буюу Зимхан Гонма гэдэг сургуулийг үүсгэжээ.




Брайвун хийдийн дээр, Нагвагийн ном хаялцах газрын дээр энэ сургууль байрладаг тул тийн нэрлэсэн ажээ.





ЗУРГААДУГААР ХЭСЭГ
БАНЧИН ЭРДЭНЭ СОНАМ ДАГБА






Хэдэн төрлийн дараа Банчин Эрдэнэ Соном Дагба 1619 онд Буддын шашны ирээдүйд агуу их нөлөө үзүүлэх нэгэн болох Бүрүлгү Дагба Жалцан болон төрвөй.

Дөрөвдүгээр Далай Лам 1617 онд гэгээн гэрэлд оров. Түүний хойт дүрээр тодорч болох хоёр хүнийг олсон байлаа.



Бүрүлгү Дагба Жалцанг төрөх үеэр солонго татан, энэ их гэгээнтний үйлсэд даган баясаж газар дэлхий хүртэл хөдөлсөн ажээ.





Урьд төрөлдөө
хэн байсан болохоо
би мэднэ...

Бага залуу байхдаа Бүрүлгү Дагба
Жалцан урьд төрлүүдээ тодорхой
санадаг байжээ.



Одоо таныг
Бүрүлгү Дагба Жалцан
хэмээн нэрлэх болно.


Николас! Бүрүлгү Дагба Жалцан яг чам шиг
6 настай байхдаа зимхан Гонмагийн Бүрүлгү
хувилгаанаар тодорч, Банчин Лам өөрөө түүнд
Бүрүлгү Дагба Жалцан хэмээх нэрийг
хайрлажээ.



Тэрээр шашны эд зүйлсийг хэнээр ч заалгалгүй зөв хэрэглэдэг байсан бөгөөд, түүнд өгсөн ямар ч том номыг төвөггүй цээжилчихдэг байжээ.




Мөн дөнгөж 9 настай байхдаа элдэв номонд тайлбар бичин, сургааль ном айлдаж эхэлжээ.



Сонгогдсон хоёр хүүхдүүд болох Бүрүлгү Дагба Жалцан болон Наваан Лувсан Жамц нарыг Брайвүн Нагбагийн дацан сургуульд орох үед тэдэнд IV Банчин Лам Лувсан Чойжи Жалцан багшилжээ.




Эцэст нь Наваан Лувсан Жамцыг IV Далай ламын хойт дүрээр тодруулж, V дугаар Далай ламын ширээнд суулгав.




Харин Бүрүлгү Дагба Жалцанг Банчин Эрдэнэ Соном Дагбагийн хойт дүрээр тодруулав.




Ингээд Бүрүлгү Дагба Жалцан бээр Банчин Соном Дагбагийн үүсгэсэн Зимхан Гонма хийдэд суух болжээ.



V дугаар Далай Лам ойролцоо орших Зимхан Огма буюу Доод хэсэгт байрлах болсон байна.



Далай лам болон Бүрүлгү Дагба Жалцан нар хоорондоо дайсагнадаг байсан хэмээн зарим хүмүүс боддог байсан нь үнэнд нийцэхгүй юм. Тэд нар нэг багштай байсан бөгөөд Гүрү багш Банчин ламынхаа дор дандаа хамтдаа суралцан, хамтдаа залбирал мөргөл хийн, эвтэй байдаг байжээ.



Гэтэл Далай ламын шавь нар Бүрүлгү Дагба Жалцангийн нэр ард олонд алдаршиж байгаад ихэд атаархдаг болчихсон байв.



Хараач,
тэрээр олон
хоногийн турш
хоол ундгүй
бясалгаж байна
шүү.



Шид
хүчийг ч
олжээ.



Бүрүлгү Дагба Жалцан
бясалгах дуртай байсан
бөгөөд Төвдийн зуу зуун
агуйд нямба хийн суудаг
байжээ.



Түүний агуйд олон хүн
хүрэлцэн ирж тахил өргөн
адис хүртдэг байв.



Үгүй ээ,Намайг энд
бясалгаж байгааг тэд нар
яаж мэдчихэв ээ. Би
уул нь ганцаараа байж
бясалгамаар л байна.



Намайг
хаашаа явсныг хүмүүст
бүү хэлээрэй. Би нямба
бясалгалаа гүйцээж
хиймээр байна.



Түүний идшид,нэр алдар түймэр шиг л
түгсэн тул тэрээр нэг агуйгаас нөгөө рүү
байнга л нүүх хэрэгтэй болдог байв.


Тэрээр алдар хүндээс зугатан ганцаар байж бясалгалаа л хийхийг хүсдэг байсан тул агуйгаас агуйд байнга нүүдэлдэг байжээ.




Бүрүлгү Дагба Жалцангийн алдар хүнд өсөхийн зэрэгцээ түүнийг эрж хайсан хүмүүсийн цуваа уртасч, хол ойроос мөргөн хүндэтгэл үзүүлэх гэсэн хүмүүс улам олширчээ.



Түвэдийн язгууртнууд төдийгүй, Монгол, Манжийн хаад ноёдын угсаатанууд хүртэл алс холоос ирж номыг нь сонсон, адис хүртдэг болсон байв.





Дагба
Жалцанд
мөргөхөөр
ирж дээ!

Далай Ламыг
хүндэтгэхгүй
л байна даа

Нэг л өдөр
тэд үүнийхээ
харигт амсах
вий



Та нар
юуны талаар
шивнэлдээд
байна?

Үгүй ээ,
Далай Лам
минь!

Юуны ч
талаар бишээ,
Дээрхийн
Гэгээнтэн минь

Нэгэн өдөр Бүрүлгү Дагба
Жалцан Чойжин буудаг
ламаар дамжуулан Найчүн
сахиустай уулзжээ.



Дагба Жалцан
ламд их олон
хүн бараалхаж
байх юм

Маш сайн
байна! Би
даган баяса



Чойжин лам
гэдэг чинь юу
гэсэн үг вэ?



Чойжин лам гэдэг нь номын сахиус тэргүүтэй өөр ертөнцийн бодгальтай харьцаж сурсан тусгай хүнийг хэлдэг юм.



Бүрүлгү Дагба Жалцан минь, та бэлэн болов уу, та авсан ам тангаргаа санаж байна уу?



Юунд бэлэн болох гэж? Ямар ам тангараг вэ?



Та нийт бусын
сахиусаар босно гэсэн
ам тангараг авсан шүү
дээ. Энэ будааг иднэ
үү! Ам тангаргаа санах
болно.

Дүлзін
минь! Та Богд
Зонховын тодруулан
сургасан Нагаржунай
Төв үзэл сургаалийг
хамгаалагч Гандангийн
нийт бусын сахиусаар
босохоо та амлахтуң!






Тэгье.
Богд Зонхов
багшийнхаа төлөө
сахусаар босъё.
Амлаж байна.

Би...
Би одоо
саналаа.



Гэхдээ надад нэг
бэрхшээл байна. Миний
сэтгэлд уур хилэн гэж огт
байдаггүй. Надад хилэн
байхгүй тул би хэрхэн
догшин хилэнт сахиус
болон босох вэ?



Санаа
бүү зов, би
тусална.



Гайхмаар юм... Энэ
гэгээнтэн лам Бүрүлгү Дагба,
Жалцанд өөрийгөө гэсэн амин
хувийн бодол огт байгаагүй ажээ.
Шашин амьтны тусын тулд
өөрийгөө бие, сэтгэлээ умартан,
босож байна шүү дээ.



НАЙМДУГААР ХЭСЭГ

Бүрүлгү Дагба Жалцан
таалал болсон нь




Ингээд Бүрүлгү Дагба Жалцанг Дээдийн номын сахиусаар босгох нөхцлийг Найчүнд бүрдүүлж эхлэв.

Тэгээд бид нар юу хийх гэж?

Бүрүлгү Дагба Жалцанд Далай ламаас ч илүү хүндэтгэл үзүүлж байгааг бид нар зүгээр хараад байж болохгүй дээ.

Бид сахилаа алдаж болохгүй дээ.

Хэрэв Далай ламыг хамгаалах зорилготой л бол бид сахилаа алдагдахгүй шүү дээ. Бурхан багш ч гэсэн урд насандаа сайн үйлийн төлөө бусдыг егүүтгэж байсан даа!




Дахиад л Бүрүлгү Дагба Жалцанг алдаршуулаад эхэллээ.


Та ямар нэг зүйл хийсэн нь дээр дээ.

Энэ ч арай хэтэрч байнаа...


Сонсож бай! Буддын шашны төлөө бид түүнээс ямар нэг аргаар салах хэрэгтэй.



Тэгээд тэд нар түүнийг хорлохыг оролджээ.



Гэтэл Бүрүлгү Дагба Жалцан бясалгалын өндөр түвшинд хүрч биеийнхээ хий, мах бодийг бүрэн хянаж чаддаг болсон байв...



... хорыг тэрээр биенээсээ зүгээр л гадагшиллуулчихаад байсан тул хор түүнд огт нөлөөлөхгүй байв.



Энэ хорны нэг дусал бүтэн сарлагийг ч үхүүлдэг байтал энэ Дагба Жалцанд огт нөлөөлөхгүй байх юм.

Ринбүүчи минь!
танд бид тахил өргөх гэсэн юм.



----Бүрүлгү Дагба
Жалцангийн өргөөнд...



Ааааааааааа...

Хаааааааааааа...



Хаа --




Хүүв--



Лан --



Оооох.



Зугтаарай.



Далай ламын шавь нар
хорлох санаагаа тавьсангүй...



Ринбүүчи
минь!




Тайвширцгаа!
Манай өрөөнд орцгоо...
Та нартай ярилцах хэрэг
байна.

Бүрүлгү Дагба Жянчин
тэднийг гайхшруулав.



Хмммм.

Дэси, Дэпа нар аа, Та
нарын юу төлөвлөөд
байгааг би сайн мэдэж
байна. Гэхдээ та нарын
санаа бүтэхгүй ээ.



Та юу яриад
байна аа?



Юу ч болоогүй
юм шиг дүр бүү
эсгэ!

Үгүй ээ, Үгүй ээ...
Та юу яриад
байна аа?

Намайг алах
гэж байгааг чинь
би мэдэж
байна.





Энэ насанд минь
намайг алах ганц арга
байгаа юм. Та нар
миний аманд хадаг
чихэж л алж болох
юм.



Юу?










Зүгээр л хийх
юм аа л гүйцээн
хийгтүн!



Ахххххххх.



Axxxxxxx!!!



Oxxxxxxx...



Хоолойндoo хадаг чихүүлэн,
амь тавих үед л Бүрүлгү Дагба
Жалцангийн таалалд бага зэрэг хатуу
хий төрсөн нь түүнд хэрэгтэй байсан
догшин хүч байлаа.



Тэгээд тэрээр гэгээн гэрэлд оров.
Тэр 38 настай байжээ.




ЕСДҮГЭЭР ХЭСЭГ:
Тэнэмэл сүнс үү? Бурхан үү?



Бүрүлгү Дагба Жалцангийн
оршуулах ёслолд хол ойроос асар
олон хүн хүрэлцэн ирсэн байлаа...







Шарилыг шатаагтун!



Би шатаах гээд оролдоод болохгүй байна шүү дээ.





Юу болоод байна аа?

Шарил нь шатахгүй байна уу даа?



Ягаад шарил нь шатахгүй байна?

Ягаад гэвэл түүнийг алчихсан тул шатахгүй байгаа биз.

Далай ламын өргөө Зимхан Огма.



Юу яриад байна аа? Түүнийг өвчнөөр нас барсан гэсэн биз дээ...

Үгүй ээ... Манай хүмүүс түүнийг хөнөөчихсөн юм.




ЮУ?

Үгүй байлгүй дээ... Тэд нар юу хийчихэв дээ...
Намайг ганцааранг минь байлгаад өг.

уучлаарай!

Бүрүлгү Дагба
Жалцан минь, би
үнэхээр мэдээгүй
шүү.



Өршөө
намайг!





Далай лам шууд л уучлал
гуйсан залбирал шүлэг
бичжээ.

Шарил
шатахгүй л
байна даа.

Тэрээр шүлэгтээ Бүрүлгү
Дагба Жалцангийн эрдэм
хүчийг хүндэтгэж явснаа
бичсэний дээр хүмүүсийн
хийсэн нүгэлд гэмшиж
байгааг харуулжээ.

Үгүй ээ,
Би учрыг нь
олохоо байлаа.







Энэ бол Далай ламаас
илгээсэн захиа, Бүрүлгү
Дагба Жалцанд өргөсөн
залбирал байгаа юм.
Чангаар уншина уу!





Залбиралыг уншиж
дуусахад шарил шууд
шатаж эхлэв.



Чи харав
уу?


Энэ чинь юуг
билэгдэнэ
вэ?

Шарил
өөрөө шатаад
эхэллээ.





Ямар лам гэхээрээ
ийм байдаг байнаа?
Өөрийг чинь алах
гэж байхад яагаад
эсэргүүцээгүй юм бэ?




Бүрүлгү Дагба Жалцангийн сойвон
лам нар багшаа шударга бусаар
алсандаа сэтгэлээр хямарч байв.

Энэ бол Төвдэд тохиосон эмгэнэлт
үйл явдлуудын эхэн байв...



Гэнэт шарилаас их хар
утаа баагив...






Бид Бүрүлгү Дагба
Жалцанг хорлосон тул
тэр үхээд, хилэнт ад
болсон үзэгдэл
гарав.

... Атгасан гар шиг утаа, Лхас
хотыг бүрхэв. Далай лам
үүнийг муу ёр хэмээн боджээ.




Түүнээс хойш Лхас хотод цөвүүн цаг эхэлжээ. Газар хөдлөн, ган зуд дараалан болж, өлсгөлөн нүүрлэв. Энэ бол Бүрүлгү Дагба Жалцанг алсан хүмүүсийн нийтийн үйлийн үр хэрхэн боловсорч байгаагийн тэмдэг байжээ.



Төвд орон даяараа хямралд
автав. Далай лам аяга цайгаа
ч тухтай ууж чадахаа болив.

Аргаа барсан Далай лам арга
чарга, зан үйл хийхдээ гарамгай
нэгэн хүнийг олов.

МИНДРОЛИНГИЙН ЛАМ




Надад таны
тус хэрэгтэй байна.
Төвдийг түйвээгч нэг ад
гарлаа. Галын түллэг зан
үйлээ хийж түүнийг дарж
өгнө үү!





Миндролин ламын галын түүлэг зан үйл нь домог болсон доо. Хамгийн хүчтэй ад чөтгөрийг ч дарж чаддаг гэж үздэг шүү.




Өөрийн бясалгалын хүчээр Миндролин ламтан “Адыг” гохдон авчирч хутгуур шанагандаа юүдээд галд хийн шатааж дардаг байв. Гэтэл энэ удаа санаанд багтамгүй хачин зүйл дахин дахин болоод байв.





Тэрээр нөгөө “Адыг” галд хийх бүр тэр нь Манзушир бурханы машид догширсон дүр болох Жигжид бурханы дүрд хувиран, галаас буцан гарч ирэн, хутгуур дээр суучихаад байж...



Дараа нь бас нэгэн удаа Миндролин лам хутгууртаа анхааралаа төвлөрүүлэн байтал ...



... Номын сахиус Сэтав машинд сэтгэл татсан үзэсгэлэнт бүсгүйн дүрээр Миндролин ламын өмнө хувиран бүжиглэснээр түүний анхааралыг сарниулчихав.



Дорж Шүгдэн хутгуураас гарч, Сэтав сахиустай хамт алга болов




Тэр адыг чи үнэхээр дарж чадахгүй байна гэж үү?

Би бүх аргыг хэрэглэлээ шүү дээ. Яагаад ч юм бүү мэд би анх удаа энэ Дорж Шүгдэн нэрт адыг дарж чадсангүй ээ. Магадгүй энэ ад биш байх...

Олон удаагийн оролдлогуудын дараа ч Далай лам Дорж шүгдэн сахиусыг дарж чадсангүй. Эцэст нь тэрээр Шүгдэн сахиусыг ад дон биш болохыг ойлгов.



Үгүй ээ. Би алдаа гаргажээ. Бүрүлгү Дагба Жалцанд би үнэхээр хор хийсэн юм байна.



Тэрээр сахиус болон боссон тул би түүнийг тамгалан батлая!

Далай лам Дорж Шүгдэнг Бүрүлгү Дагба Жалцангийн хувилгаан, энэ цаг үеийн маргаангүй сахиус хэмээн тамгатай батламж захиа болон залбирал бичиж өгчээ.



V Далай ламаас Дорж Шүгдэнд өргөсөн магтаал
Хум

Уг анхны хоосон агаараас үл хөдлөх боловч

Аянганаас ч машид түргэн их хүчит

Сайн мууг ялгагч баатар зоригт таныг

Энд урин залья! морилон хайрла!

Хуврагийн хувцаст хирсний арьсан малгайг асаасан

Баруунаар чимэгт бороохой, зүүнээр хүний зүрх барьсан

Лус, гарьд зэрэг элдэв хөлөг унасан

Үхээрийн газрын мам нарыг номхруулагч таныг магтмуй!

Тангарагийн эд, гадаад дотоод нууцын тахил дором

Мэлмийн болгоолт зэрэг элдэв тахилыг жигдрүүлэн өргөмүй

Хэдий миний урьдын ерөөл хүсэл хүнд байсан ч

Хүчит хувилгааны дүрээ бүү зогсоо!

гэмээ наминчилан гэмшье!

Бие, хэл, сэтгэлийн үүдээрээ таныг бишрэн магтая

Багш шавь өглөгийн эзэд хийгээд бидний нөхөр сэлтэд

Сайн сайхныг хайрлан, саад бүхнийг даран зохио.

Ертөнц хийгээд номын аливаа үйлсийг шинийн саран мэт


арвитгагтун!

Түүнчлэн бидний хүсэл ерөөлийг түргэн бүтээж


Дээдийн хутгийг хайрлан зохио

Сэтгэлчлэнгийн чандмань эрдэнэ мэт

Гурван эрдэнийн авралаар байнга өршөө!



Түүнээс хойш Лхас хотын тэнгэрт нүүгэлтэн байсан хар гарын дүр байдалт үүл арилав. Мал амьтан үхэх, цас мөндөр унах, газар хөдлөх тэргүүтэн өлзий бус тэмдэг ч зогсов. Юмс хуучин байдалдаа эргэн орж, цэцэг жимс дэлгэрчээ.



Хөөх, Ингэж л Дорж Шүгдэн маань сахиусанд босчээ... Үнэхээр их саадыг даван сахиус болж дээ.

Тийм ээ, Николас! Тэрээр энэ их саад бэрхшээлийг даван сахиусанд боссон нь бидний л тусын тулд юм шүү дээ!



ДРАВДУГААР ХЭСЭГ

Сажийн хийд рүү

Тэгээд Дорж Шүгдэн урьд төрөлдөө Сажа Бандита лам байсны хувьд Сажийн хийдийн лам нартай үйлийн барилдлага хүчтэй байсан тул Сажийн хийдрүү морилжээ.



Тэр үеийн Сажийн хийдийн лам нар эрдэм оюунаараа маш алдартай номч мэргэд байсан тул Дорж Шүгдэнг хэн болохыг нь даруй таньж, тэр дор нь ширээнд залж, түүнд тусгайлан шүтээний хийд орон барьж, тахиx болжээ.



Ийнхүү Дорж Шүгдэнг анх Сажийн хийдэд шүтдэг болсон юм. Сажийн лам дээдэс нар Дорж Шүгдэн сахиус энэ цагаас эхлэн номын магад сахиус болсныг, цаг өнгөрөх тутам түүний эрдэм чадал нь хүчирхэг болох тухай зарлажээ.





Дорж Шүгдэн сахиус зөвхөн сүм хийд төдийгүй, хар хүмүүсийн дотор ч өргөн дэлгэрч, айл гэрийн бурхан шүтээнд хүндтэй залагдах сахиус болон тодорчээ. Ингээд тэр цагаас хойш 300 жилийн турш Сажийн сүм хийдүүдэд тахин шүтсээр иржээ.

Энд Дорж Шүгдэнд зориулан бичсэн далай шиг их магтаал зохиолуудаас дуслын төдий нэгийг үзүүлэх аваас Цогт хүчит Дорж Шүгдэн сахиусанд машинд гүнзгий сүсэг бишрэлийн үүднээс тавьсан магтаалыг дурдах хэрэгтэй. Дорж Шүгдэн сахиусын нигүүсэл ямар их цаглашгүй гүнзгий, номыг сахих буянт үйлс нь ямар их ариун дээд болохыг нь магтсан үг бүрийг нь анхааралтай сонсогтун:

Сажийн лам Хүнгэн Наваан Гунгаа Лодойгоос Дорж Шүгдэн сахиусанд өргөсөн магтаал.

Анханд Татагатагийн шашинд орохын цагт
Винайг баригч гэлэнгийн дүрээр босоноор
Шрಾವагийн сав номыг хоцроолгүй сахьсан танд дор мөргөмүй!

Завсарт тоолшгүй олон бурхад бодьс адва нарын өмнө
Ерөөхүйн хийгээд орохуйн бодьс аддын тангарга авах үедээ
Номын сахиус болохын бивангардыг хүртсэнээр
Бодьс адзын хамаг номыг хоцроолгүй сахих болсон танд мөргөмүй.
Дандарын далайн их хот мандалд
Очирдараас эрх хүртэн тангарагыг авснаар
Гүнзгий дандарын хамаг номыг хоцроолгүй сахих танд мөргөмүй

Ялангуяа цастуулсаар хүрээлэгдсэн умардын энэ оронд
Бурханы нар хэдий шууд тусаагүй ч түүний нигүүсэлийн хүчээр
Буй болсон шашны дөрвөн ёсыг ялгалгүй сахих танд мөргөмүй.

Гурван сав ном, их дандарс болон шашдирыг
Өөрийн үзлээр сайтар номлосон шашныг баригч дээдэс бүхнийг
сахигч, Тэдгээр мэргэдийн зарлигийг
биелүүлэгч болсон танд мөргөмүй.

Мэргэд бандита, дуун хөрвүүлэгч, номын хаад сайд нарын барин босгосон
хуврагийн чуулганы орших сүм хийд бүхнийг хоцроолгүй сахигч
Их сахиус танд мөргөмүй!

Бүх Төвдийн орон, Дээд доод Ари төвийн Уцан, доод Докамын орны ард
олны

Гагц сахиус, аврал, түшиг, садан, нөхөр нь болсон тул
Та бол Цаст орны гол эзэн, Танд мөргөмүй!


Сайн цагийн мянган бурхан бүгдийн сахиус
Хорт шулмасын хүчийг даран зохиогч
Туулсан бурханы төгс гэгээрлийг үзүүлэн
Бурхны зохионгуйгаар явах танд мөргөмүй!

Товчдоо, лагшин, зарлиг, таалалын гурван нууцаараа
Хорвоогийн далайд төөрч живсэн амьтан нугуудад
Төгс гэтлэхүйн хутгийг зогсолтгүй хайрлагч танд мөргөмүй!


Яруу аялгуун далайн магтаалаар таныг магтсанаар
Таны таалалдалин баясгалан, нигүүсэл асралыг арвитгасны хүчээр
Үл зохилдохыг амирлуулан, буян номыг арвитгах зэрэг
Хамаг хүсэл ерөөлийг номын дагуу бүтээн зохио!



Арван нэгдүгээр хэсэг:
ДАГБУ БАДАМБАЗАР



Хэдэн зуун жилийн дараа Дагбу
Бадамбазар хэмээх Гэлүг ёсны
их ламтан Төвдэд гарчээ. Тэрээр
бурхны ариун орноор зорчдог
байснаараа ихэд алдаршив.



Нэгэн удаа Дагбу Базар лам бясалгаж
байх үеэр ирээдүй цагийн бурхан
Майдарын ариун орон Төгс баясгалант
тэнгэрийн оронд зорчив.



Дүлзін Дагба Жалцан
минь, Дорж Шүгдэнгийн хот
мандал, дамжлагын нууцыг
номлож хайрлана уу?

Тэнгэр нарын их чуулган дотор
Дүлзін Дагба Жалцан оршин байв.



Дүлзін Дагба Жалцангийн зүрхэнээс солонгон
гэрэл гарч, Богд Зонхов зүрхэнд оров.



Тэгээд Зонховын зүрхнээс гэрэл буцан гарч Дүлзін
Дагба Жалцангийн зүрхэнд шингэн оров.




Дулзин Дагба Жалдангийн зүрхэнээс гарсан гэрэл Богд Зонховын суудалд шингэв.



Гэнэт Зонховын суудлаас Дорж Шүгдэнгийн гэрэл цацарсан хот мандал бий болов.



Дагбу Бадамбазар дараа нь ариун дээд сахиусын аман увидас дамжлагийг Дорж Шүгдэн сахиусын аман гэгээнээс, өөрөөс нь хүртэв.



Номоо айлдсаны дараа мандал нөхөд сэлт нь гэрэлд шингэн дахин суудал дор шингэв.



Дагбу Бадамбазар бясалгалаа өндөрлөөд, дамжлагын лам нарын залбирал болон Дорж Шүгдэн сахиусаас хүртсэн аман увьдасаа сийрүүлэн бичжээ.

Би үүнийг бичиж авах хэрэгтэй. Энэ бол маш үнэ цэнэтэй увидас тул олон лам бясалгач нарт тустай байх болно.

Пабонка минь! Энэ бол Дорж Шүгдэн сахиусын ариун дамжлага болой. Би чамд хайрлах тул өөрөө төдийгүй бусадтайгаа хуваалцан үзтүгэй!



Тэрээр энэ дамжлагийг өөрийн хамгийн ойрын шавь Авралт Богд Пабонка Ринбүүчид(1878-1941) хайрлажээ.

АРВАН ХОЁРДУГААР ХЭСЭГ
Дээрхийн Гэгээнтэн Авралт Богд
Пабонка Ринбүүчи



Пабонка Ринбүүчи бол
XX зууны Буддын шашны
хамгийн агуу их лам, Төвдийн
багш нарын дундаас хамгийн
нөлөө бүхий лам байжээ



Түүнийг төрөх үед гэрт нь
гэрэл цацарч...



гадаа нь байсан олон хүмүүс байшин
дээр нь сахиус заларч байгааг нүдээр
үзжээ.

Түүнийг 7 настай байхад нь алдарт Шарав Ринбүүчи Чойжи Лувсан Даржэ лам тодруулсан байна.


Чи Сэра Мэй дацанд орж номонд суралцугтун! Ирээдүйд чи маш сайн лам болно.

Заа, Ринбүүчи. Баярлаллаа. Би суралцах болно.

Тэгвэл яагаад түүнийг Пабонка Ринбүүчи гэдэг байсан юм бэ?

Пабонка Ринбүүчиг анх Жанжаа Ролбийдорж (1717-1786) тэргүүтэй олон мэргэн лам нараар дараалан төрж байсан хүний хойт дүрээр тодруулсан юм.

Энэ зүгээр улс төрөөс л болсон хэрэг. Жанжаа гэдэг нэрийг нь дурсахгүй байхаар болж, түүнийг Пабонка гэхээр болжээ.



Тэр багадаа идэх хоол унд мөнгө төгрөггүй их л ядуу байжээ.

Харин бусад лам нарт хамгийн багадаа л гэхэд бага ч гэсэн арвайн гурилтай байв. Тиймээс заримдаа тэр хоолгүй болонгуутаа сүмээс гарч хоолны утаа элсээр дүүргээд дээр нь байгаа бага зэрэг арвайн гурилаа тавиад үнэртэн, хааяа амсдаг байжээ.



Тийм байдлаар тэр олон хоног өл даадаг байв.



Хэдийгээр тэрээр Сэра Мэй дацанд дунд зэргийн дүнтэй байж дандаа бусдад мунхагаараа дуудуулдаг байсан боловч Гэвшийн дамжаагаа барьжээ.





Пабонка Ринбүүчи бээр Дагбо Лам Жамбал Лхүндүвд шавь орж, 10 гаруй жилийн турш Ламримыг судлан, багшийг ариунаар шүтэн нугаршгүй хичээл зүтгэлийн ачаар мэргэн лам болжээ.



Эгэлийн бус бясалгагч, Пабонка Ринбүүчи, Зөвхөн сайн лам багш байсан төдийгүй Дэмчиг бурханы биеийн хот мандал болон, Нархажод бурханы ном увидасыг хайрладаг байснаараа машид алдаршин нэр хүнд нь дуурсагдав.

Нэгэн удаа Пабонка Ринбүүчи
Төвдийн Симбүри дэхь агуйд
морилон, Дэмчиг бурханы дүрд
мөргөж байв.



Одооноос эхлэн
дараагийн 7 үеийн
шавь нар чинь хэрэв
Дэмчигийн увидасыг
маань бясалгаваас
хамгаалан сахих
болно.



Дэмчиг
бурхан

Ингэж Дэмчиг бурханыг
зарлиглах үед түүний амнаас маш
их рашаан урсан гарчээ.



Энэ рашааныг
тосон авч, маш
хүчтэй эмийн үрэл
бэлтгэжээ.



Түүнээс хойш
мянга мянган хүмүүс
Пабонка Ринбүүчигээс
Дэмчигийн биеийн
хот мандалын эрх,
тайлбарын ном
увидасыг хүртжээ.
Пабонка Ринбүүчи
ламыг одоо хүртэл
олон дээдэс мэргэд
Дэмчиг бурханы
өөрийн хувилгаан гэдэг
билээ.





Пабонка Ринбүүчи багшийн нэр алдар машид дэлгэрсэн тул түүний номыг сонсохоор мянга мянган хүмүүс хүрэлцэн ирдэг байлаа.




Хэдийгээр тэр үед чанга яригч байгаагүй боловч түүний хоолой маш чанга байсан болохоор хүн бүр түүний номыг сонсож чаддаг байв.



Нэгэн өдөр цэргийн жанжин Дапон Цаго Пабонка Ринбүүчигийн номонд ирж гэнэ. Тэрээр маш омогтой хүн байсан бөгөөд энэ ламын юунь тийм гайхмаар байгааг зүгээр л харахаар ирсэн байв. Хэдийгээр номонд ирсэн хүн зэвсэг зүүх хийгээд малгай өмсөх ёсгүй боловч тэрээр түүнийг тоосонгүй.




Гэхдээ Дапон Цаго бээр Пабонка Ринбүүчигийн номыг сонсож эхлээд л сэтгэл нь өөрчлөгдөж эхэлсэн байдаг.



Энэ ламын ухаан билгүүн гарамгай юм гээч...

Гэнэт, тэрээр омгийн эрхээр зэвсэг зүүж ирснээ санажээ.






Далон ихэд ичиж, номхороод номноос чимээгүйхэн гарч одов.



Далон нэгэн өдөр лам дээр хүрэлцэн ирж...

Ринбүүчи минь!
гэнэнгийн сахил хайрлаач!!!



Түүнээс хойш тэрбээр Пабонка Ринбүүчиг ном айлдах бүрдирдэг болсон байв.



ХIII Далай лам Пабонка Ринбүүчи ламын нэр алдар хэрхэн өссөнийг мэдээд, түүний номлолыг нарийн сайн шалгасан боловч, ямар ч алдаа олоогүй ажээ.



Пабонка Ринбүүчи маш их алдаршлаа. Түүний сургааль үнэхээр зөв үү?

Би түүний номыг машид анхаарч сонсоход ямар ч алдаа гэм байхгүй байна.



Ринбүүчи!
Энэ Ламрим чинь
ямар учиртай юм бэ?
Уг гарал нь хаанаас
вэ? Уг гарал нь билэг
чанар төгс үү?

Тэр үед Пабонка Ринбүүчи тэр үедээ хүмүүсийн
сайн мэддэггүй Шар жүд буюу Өмнийн дамжлагын
ёсоор Ламрим номлож, байсан бөгөөд олон мэргэд энэ
дамжлагын уг эхийн талаар ном хаялцаж байв.

Мэдээж,
билиг чанар төгс
болой. Эдгээр увидасыг
би багшаасаа хүртсэн
бөгөөд манай багш бол
алдаагүй дээд төрөлхтөн
юм.



Энэ Бодь мөрийн зэрэг
дамжлагын ямар гаралтайг
тайлбарлах хэрэгтэй
гэж Пабонка Ринбүүчид
хэлэгтүн. Үнэхээр ийм
дамжлага байдаг эсэхийг
ч тайлбарлаг!

Далай лам уг асуудлаар
Пабонка ламаас шалган
асуух хэрэгтэй гэж үзжээ.

Дээрхийн Гэгээнтэн XIII
Далай лам таны дамжлага
үнэхээр байдаг эсэх талаар
асуулгаж байна. Ринбүүчи
одоо яах вэ?



Ийм нөхцөлд
би хариулахаас
аргагүй. Би хэлнэ
чи бичээрэй.

Би таны Ламримын Өмнө зүгийн дамжлагын талаархи тавьсан асуудал тань хариулан бичиж байна. Бурхан багш үүнийг нэгэн чухал судартаа айлдсан байдаг. Энэ мөчид та номын өргөөндөө заларч байна. Та ардаа байгаа номын сангийнхаа баруун талаас 3 дахь тавиур руу харатун! Дээрээсээ 2 дахь тавиурын, зүүнээсээ 5 дахь хүрэн хавтастай ном бий. Түүний 149 дүгээр хуудасны 4 дэх мөр дээр энэ талаар тодорхой байгаа.

Энэ чинь Ганжуураас татсан баталгаа юм аа. Мөн түүнчлэн, Асанга Ринбүүчигийн айлдсан номыг үзэгтүн!

Энэ ном таны номын сангийн 3 дугаар тавиур дээр улбар шар хавтастай байгаа, түүнийг нээгээд 89 дүгээр хуудасны 4-с 10 мөрүүдийн хооронд та тайлбарыг нь үзэх болно.



Үүнээс гадна Төвдийн уламжлалаас ч баталгаа бий. Та өөрийнхөө багш, бурхан болсон лам Пурцог Жамба Ринбүүчигийн бүрэн зохиолын 4 дэх ботийг үзнэ үү. Энэ ном таны унтлагын өрөөний хамгийн дээд тавиур дээр байгаа харин баталгаа нь 30 дугаар хуудас дээр байна.



Гэр номыг одоохон надад аваад аль.

Яг одоо.




Пабонка Ринбүүчи яг үнэн хэлжээ. Би түүнийг яагаад ч буруутгаж чадашгүй юм байна.



Пабонка Ринбүүчиг сүсэглэн биширдэг хүмүүс улам нэмэгдэн, Төвд нутгийн хаа сайгүй Гэлүг болон Нинма сүм хийдүүд аль алинд нь урин залж, ном айлдуулдаг байв. Тэрээр аливаа хүмүүсийн сэтгэл оюуны чадал хүчийг сайтар мэдсэний үндсэн дээр уран аргаар тааруулан номлодог байв. Тэрээр Гэлүг ёсны лам боловч, бусад ёсны ном сургаалийг ч төгс зүйтэйгээр номлодог байжээ.



Пабонка Ринбүүчи ламын хамгийн алдартай ном сургааль бол 1921 онд Ламримын тайлбар номыг мянга мянган шавь нартаа айлдсан явдал байлаа.




Түүний номонд суусан алдарт лам нарын эгнээнд Дээрхийн Гэгээнтэн Тижан Ринбүүчи болон Дээрхийн Гэгээнтэн Лин Ринбүүчи нар ч багтдаг байжээ.




Гүнзгий билгүүнтэй шавь нарт энэ бол маш агуу хийгээд, гүнзгий увидас байсан бөгөөд оюун ухаан мухар шавь нарт ч ойлгон ухаарахад амар байв.



Энэхүү Ламрим ном сургаалийг “Гэтлэхүйн Гарын Авлага” хэмээх нэрээр түүний хамгийн ойрын шавь нарын нэг болох Дээрхийн Гэгээнтэн Трижан Ринбүүчи үсэгт буулган хэвлүүлжээ.




Пабонка Ринбүүчигийн бүтээсэн олон гайхамшигт номын дотор Дорж Шүгдэн сахиусын Гансол буюу “Хамаг Зүг Бүхэнд Ялсан Яруу Эгшигт Дамарын Дуун” зохиол орох бөгөөд энэ нь түүний багш Дагбу Бадамбазарын бясалгал ариун үзэгдэл дээр үндэслэгджээ.



Одооноос эхлэн Дорж Шүгдэн Гэлүг ёсны шинэ сахиус боллоо.


Бид залбирал тавин түүнийг шүтсэнээр үйлсээ даатгах хэрэгтэй...




Төвдэд 1949 онд үймээн самуун дэгдэх үеэр...

Ард олон Төвдээс дүрвэж байна, Ринбүүчи. дайн гарцаагүй болох нээ.

Юу болж байна даа?



Санаа алдаж...
- Би Төвдийг орхин дүрвэж чадахгүй байх аа. Гэхдээ энд үлдвэл шашны ном устаж магадгүй юм.



Пабонка Ринбүүчи бээр Дорж Шүгдэнгийн бүх дамжлагыг бусад олон увидасын хамтаар өөрийнхөө хамгийн номтой шавь болох Тижан Ринбүүчид хайрлахаар болжээ.




Тижан Ринбүүчи!
Эдгээр номын увидасыг чамд өгөхөөр боллоо.
Одооноос эхлэн энэ уламжлалыг хадгалан, дэлхий ертөнцтэй хуваалцах эсэх нь чамаас л хамаарах болж байна!



АРВАН ГУРАВДУГААР ХЭСЭГ:

Дээрхийн Гэгээнтэн Тижан
Ринбүүчи





Тижан Ринбүүчи бээр 1901
оны өвөл Төвдийн Гунтан
хэмээх газарт төржээ.



Түүнийг төрөх үеэр олон гайхамшигт
үзэгдэл гарсан бөгөөд, Гунтан Лавран
Трокангийн цэцэрлэгт ургасан тоор мод
цэцэглэж 30 ширхэг тоор ургасан гэдэг.

Хөлд орохоосоо өмнө тэр Бурханы дүр зураг хийгээд тахил, очир хонх дамар болон цан зэрэгт маш бишрэлтэй ханддаг байжээ.




Мөн ном хаялцаж буй лам нарыг харж баясан тэднийг дуурайдаг байв.






Тэрээр 4 настайдаа Лхас хотын Тижан Лавранд шавилсан бөгөөд дараа нь Чойсанд морилжээ.




Жилийн дараа Дээрхийн Гэгээн Чойсанд байхдаа нэгэн гайхалтай ламтай учирсан нь түүний багш Пабонка Ринбүүчи байсан бөгөөд тэр мөчөөс эхлэн багш шавийн ариун холбоо үүсчээ.







Тижан Ринбүүчиг Шарын шашны тэргүүн 69 дүгээр Гандангийн ширээг баригч Жанчүв Чойнпэлийн бүрүлгү буюу хувилгаан дүрээр тодруулсан байна. Түүний өөр хувилгаан дүрүүдийн дотор 85 дугаар Гандан трипа Тричэн Лувсан Чүлтим Балдан мөн багтдаг ажээ.




Бага залуугаасаа Тижан Ринбүүчи номонд ч мэргэн ном хаялцахдаа ч мэргэн лам байсан бөгөөд 19 насандаа л 20 жил үзээж хүртдэг Гэвшийн дамжааг барьсан байна.



Тэрбээр гэвшийн хамгийн дээд зэрэг болох Лхаарамба болоод зогсохгүй XIII Далай ламаас зиндаагаар 3-рт орсон хэмээн шагнагдаж байв.



Хорин нэгэн насандаа Пабонка Ринбүүчигээс Нархажид бурханы Синдуура мандалын ван, Дагбу ламын 13 ариун үзэгдэл, Манзуширийн шашдир, Намсрайн увидас тэргүүтэн олон номын адис хүртвэй.



Жалчин Дорж Шүгдэн хэмээх нэрт, намайг өчүүхэн нярай байхаас эхлэн, хайрт эх мэт сахин, тоолшгүй олон удаа аварч байсан даа.

Энэ үед Тижан Ринбүүчи бээр Пабонка Ринбүүчигийн айлдсан Ламримыг сонсоод “Гэтлэхүйн Гарын Авлага” номоо бичсэн билээ.




Тижан Ринбүүчи 20 гаруй наснаасаа Төвдийн газар сайгүй заларч, Гэлүг ёсны сүм хийдүүдийн лам нарт номын хур буулгаж байв.

Энэ Сажийн хийдийнхэн юу хүссэн юм бол?

Тэд таныг номын хураа буулгахыг хүсч байна... Дээр Нинмагийн хийдийн лам нар танаас номоо хайрлахыг хүсч байсан адил энэ сүмийнхэн ном хүсчээ. Таныг урин залж байна гэнээ. Үнэндээ, маш олон Сажа, Нинмагийн лам хуваргаас номын заллага ирдэг байв.

Тиймээс Тижан Ринбүүчи олон мянган сүм хийдүүдэд номын хураа буулгадаг байв.



Нэгэн удаа Тижан Ринбүүчи Цунмо
Цал хэмээх нэгэн сүмд морилон тэнд
байсан Дүлзин Дагба Жалцангийн
суварганд тахил өргөжээ.

Дүлзин Богдын
үрлийг хадгалсан ямар
адис, өлзийтэй суварга
вэ? Би ч их азтай
байна даа.





Бололгүй
яахав.

Ринбүүчи минь, Та
усан тахил өргөж
өгөөч?

Бид
суврагаа нээх
хэрэгтэй дээ.

Хуврагууд суврагаа нээж усан тахил
өргөхөөр болжээ.



Энэ
дотор юу байх
нь энэ вэ?



Дүлзин Дагба
Жалцангийн ариун
лагшинг хуврагийн
хувцастайгаар залсан
нь энэ!

Огт ялзарч муудсан
шинж алгаа... Хараач!
түүний үс нь ургасан
байна!



Ариун
Шагшаавадтаны
анхилам үнэр
ханхалж байна.
Ямар гээч ариун
хувраг вэ?



Гайхалтай.



Далай ламыг гэгээн гэрэлд орох үед
Трижан Ринбүүчи түүний лагшингийн
үрлийг хадгалах ажилд оролцжээ.



У Далай ламын 1933 онд бичсэн
“Ертөнцийн цор ганц чимэг алтан
үндэс” хэмээгдэх номын дагуу зүйл
бүрийн эрдэнийн бумба тэргүүтэнийг
байрлуулжээ.

Алтан ширээг харуулан:
- Дөрвөн талд нь зургаан
мутарт Гомбын бумба,
Чойжоогийн бумба,
Балданлхамын бумба, эр, эм
ягчисын бумба болон, Дорж
Шүгдэнгийн таван аймгийн
бумбыг тус тус
байрлуулъя.



Удалгүй XIV Далай ламыг тодруулахад,
Тижан Ринбүүчиг номын багшаар нь
томилжээ.


Энэхүү тахил өргөснөөр
Ринбүүчи таны өлмий бат
оршин, шашин хийгээд би
тэргүүтэй зургаан зүйл
амьтныг авран сахих
болтугай.

Тижан Ринбүүчи 41 насандаа
Пабонка Ринбүүчи ламд өргөл тахил
өргөв.




Би ч бас танд талархаж
байгаагаа илэрхийлмүй! Та
Жалдан Шүгдэнгийн үйлсийн
зан үйлс: шүтэхийн утсан
хэлхээ, саадыг дарах зан үйл,
дормоор саадыг дарах зан үйл,
түллэгийн зан үйл болон эд
баялагийг дэлгэрүүлэх зан үйл
зэргийг
бичсэнд машид баясаж
байна.







Тижан Ринбүүчи минь!
Эдгээр номуудыг бичиж
амжихгүй шиг байна.
Санаж байгаагаа сайн
магадлаад өөрийн тэмдэглэж
авснаа үндэс болгон эдгээр
номуудыг бичин
төгсгөгтүн!




Миний хэлсэнд
суурилан, бусад зан үйлийг ч
адил гүйцэт бичиж сийрүүлээд
элдэв зан үйлийн номоо бичигтүн!
Намайг энэ сахиустай холбоотой
ном номлох бүр та дандаа байж
таардаг байсан учраас энэ бүхнийг
танд даалгаж байгаа юм!



Пабонка Ринбүүчи 1941 онд Гэгээн гэрэлд орж, Тижан Ринбүүчи машинд гашуудав.



Багш маань юу зарлиглаад байсныг одоо л ойлголоо. Тэрээр удахгүй болсноо мэдэж байсан тул энэхүү номыг надаар бичүүлэхийг хүсээд байж дээ.




Энэ сургааль дамжлагыг хадгалж үлдээхийн тулд Тижан Ринбүүчи “Сахиусын далайг баясах Яруу аялгуу” нэртэй дэлгэрэнгүй тайлбар ном бичсэн нь өнөөгийн Дорж Шүгдэн сахиусын магад эх сурвалж болж байна.



Дээрхийн Гэгээнтэн Авралт Богд 1959 онд энэ номын дамжлагаа Энэтхэгт бүрэн эхээр нь авчирсан бөгөөд, олон тооны лам хувраг нар шашнаа дахин дэлгэрүүлэхэд асар их тустай болжээ.



Тижан Ринбүүчи манай цаг
үеийн хамгийн алдарт лам
болсон бөгөөд XIV дүгээр
Далай ламын багш гэдгээр ихэд
алдаршсан билээ.



Тижан Ринбүүчигийн ачаар л
мянга мянган лам хувраг нар Дорж
Шүгдэнгийн ван авч, энэ увидас
сургаалийг дэлхий дахинаа түгээн
дэлгэрүүлж, тус эрдмийг нь хүртэх хувь
завшаантай болсон билээ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ:
ОЛДСОН НЬ






... Ямар гайхмаар түүх вэ?

Дорж Шүгдэн манай цагийг эзэлсэн сахнус юм шүү...



Энэ Дорж Шүгдэнгийн хөргийг авна уу. Түүний тарни ард нь байгаа. Чамайг байнга сахин хамгаалах болно! Би амлаж байна!



Николас! Чи энд байсан юм уу! Чамайг газар сайгүй хайлаа. Ясан их санаа зовов оо.

Дорж Шүгдэнгийн тарни: УМ БАЗРА ВИКИ БИТАНА СУУХАА.



Тэр
дажгүй байгаа.
Чамайг хүлээх
ялдамд би түүнд
түүх ярьж өгөөд
байж байлаа.

Би эндайх
зүйлгүй байлаа,
Ээжээ!





Бид явахгүй бол
болохгүй. Автобус
хүлээж байгаа... Танд
түүнийг харж хандаж
байсанд баярлаллаа.

Баярлаллаа хүндэт
лам гуай! Дорж Шүгдэн
сахиус... намайг сахин
хамгаалж байлаа. Тэр
таныг ч энд залан
авчирсан шүү дээ.



ХЭН ГЭНЭЭ?







Дорж Шүгдэнгийн талаар илүү
ихийг мэдэхийг хүсч байвал
DorjeShugden.net хуудас руу
орно уу.

Монголд Дорж Шүгдэн Их сахиусыг хэрхэн шүтэж ирсэн түүхээс



**МОНГОЛЫН ТУСГААР
ТОГТНОЛЫН
УДИРДАГЧ, VIII БОГД
ЖИВЗАНДАМБА
(1869-1924)**



**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН ЧОЙЖИН
ЛУВСАНХАЙДАВ
(1872-1918)**



**ЗАВА ДАМДИН
ГАВЖ
(1867-1937)**

Бүрүлгү Дагба Жалцан ламыг (1617–1682) сахиусанд босохоос өмнө зөвхөн Төвдүүдээс гадна Халх, Ойрад, Өвөр Монгол төдийгүй Манж, Хятадын иргэд ч олноороо шавь нь болцгоон, тахин, шүтдэг байсан нь тэмдэглэгдэн үлджээ. Тэдгээрийн дунд эгэл сүсэгтэн нараас гадна Монголын олон дээдэс мэргэд байсан юм.

Зая бандита Лувсан Пэрэнлай (1642-1708), Өндөр Гэгээн Занбазар /1635-1723/, нарыг ч шавь нь байсан хэмээх аман яриа байдаг. Харин сахиусанд босоноос нь хойш Дорж Шүгдэн сахиусыг IV Богд Жавзандамба, VIII Богд Жавзандамба, Сүмбэ Хамба Ишбалжир, Агваанхайдав, Агваанлуvsан, Агваанбалдан, Лувсанхайдав, Заваа Дамдин, Гүрүдэва Ринбүчи тэргүүтэй олон дээдэс “Шарын шашны нууц, машид дошгин сахиус” хэмээн шүтэж ирсэн нь түүхэн баримтаар батлагддаг.

“Дорж Чан” Монгол Ринбүүчи багш Гүрүдэва



Эцэст нь Монголын шашны сэргэн мандалтын эцэг, Жигжидбурханы бодит дүр хувилгаан “Монгол Ринбүүчи багш” хэмээн дэлхий даяар алдаршсан Гүрүдэва Ринбүүчи бээр ч тэр үедээ хэцүүхэн байдал байсан Монголын шашныг сэргээн дэлгэрүүлэх агуу их үйлсээ Дорж Шүгдэн сахиусанд даатгаснаар онцгой их гавъяа байгуулсныг Монголын ард түмэн зүрх сэтгэлдээ бишрэн шүтэж байгаа билээ.

Их Сахиусын дээдийн ариун үйлс даян дэлхий болон Монголын уудам орноо улам дэлгэрэн бадрах болтугай!

Монгол оронд Дорж Шүгдэн сахиусыг залж,
тахин шүтэж байсан шүтээн дүрүүдээс:



XIX зууны үе, Чойжин ламын сүм музей



XIX зууны үе
Чойжин ламын сүм музей



XIX зууны үе
Богд хааны ордон музей



www.dorjeshugden.net